

**БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧИД**



**АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН  
ХУРАЛ, ТҮҮНИЙ ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
2014 ОНЫ III, IV УЛИРЛЫН  
ТОГТООЛЫН ЭМХТГЭЛ**

2015 он



## АГУУЛГА

№	Тогтоолын тэргүү	Огноо, дугаар	Хуудасны дугаар
1	Журам батлах тухай	2014.08.29, № 110	5
2	Журам батлах тухай	2014.09.10 № 115	8
3	Журам батлах тухай	2014.09.10 № 117	12
4	Зарим газар нутгийг орон нутгийн тусгай хамгаалалтанд авах тухай	2014.09.10 № 118	18
5	Төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах арга хэмжээнд зарцуулах зардлын хувь хэмжээ тогтоох тухай	2014.10.02 № 121	19
6	Комисс томилох тухай	2014.10.02 № 122	21
7	Орон нутгийн өмчит хуулийн этгээд байгуулах тухай	2014.10.20 № 130	23
8	Ой тэмдэглэх тухай	2014.12.05 № 141	24
9	Мэргэжлийн боловсролыг дэмжих тухай	2014.12.15 № 153	26
10	Орон нутгийн өмчийн талаар авах арга хэмжээний тухай	2014.12.15 № 154	31
11	Улсын сайн малчинд уламжлах тухай	2014.12.18 № 161	33
12	Тайлангийн тухай	2014.12.19 № 12/1	34
13	Төсөвт тодотгол хийх тухай	2014.12.19 № 12/2	37







**БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2014.08.29

№ 110

Номгон

**Журам батлах тухай**

Урьдчилан төлөвлөж, нарийвчлан тооцож төсөвт тусгах боломжгүй, тухайн жилийн дундуур зайлшгүй санхүүжүүлэх зарим зардал болон аймгийн ИТХ-аас хуулиар олгогдсон бүрэн эрхээ хэрэгжүүлэхтэй холбоотой цаг үеийн шинжтэй зарим арга хэмжээг санхүүжүүлэх зориулалт бүхий нөөц хөрөнгийг баталж, зарцуулах шаардлагатай байгааг тэмдэглээд аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээс **ТОГТООХ** нь:

Нэг. “Аймгийн ИТХ-ын нөөц хөрөнгийг зарцуулах журам” –ыг хавсралтаар баталсугай.

Хоёр. Журмын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн ИТХ-ын нарийн бичгийн дарга /Д.Юндэнбазар/-д даалгасугай.

**ДАРГА Д.ШИРМЭН**

## **АЙМГИЙН ИТХ-ЫН НӨӨЦ ХӨРӨНГИЙГ ЗАРЦУУЛАХ ЖУРАМ**

### **Нэг. Нийтлэг үндэслэл**

1.1 Урьдчилан төлөвлөх, нарийвчлан тооцож төсөвт тусгах боломжгүй, тухайн төсвийн жилийн дундуур зайлшгүй санхүүжилт гаргах шаардлагатай зарим зардлыг санхүүжүүлэх болон аймгийн ИТХ-аас хуулиар олгогдсон бүрэн эрхээ хэрэгжүүлэхтэй холбоотой цаг үеийн шинжтэй зарим арга хэмжээг санхүүжүүлэх зориулалт бүхий ИТХ-ын нөөц хөрөнгийг зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнахад энэхүү журмыг мөрдөнө.

### **Хоёр. Аймгийн ИТХ-ын нөөц хөрөнгийн зориулалт**

2.1 Аймгийн ИТХ-ын нөөц хөрөнгийг дор дурдсан арга хэмжээг санхүүжүүлэхэд зориулна:

- 2.1.1 Аймгийн ИТХ-ын бүрэн эрхийн хүрээнд хурлаас томилогдсон төлөөлөгчдийн хурлын хороо болон ажлын хэсгээс зохион байгуулах хяналт шалгалтын ажил
- 2.1.2 Олон нийтийн үүсгэл санаачилгыг хөгжүүлэх, тэдэнд дэмжлэг үзүүлэх
- 2.1.3 Иргэдийн эрх, эрх чөлөөг хангах чиглэлээр зохион байгуулах ажил, арга хэмжээ
- 2.1.4 Гадаад, дотоодын хүндэт зочдод хүндэтгэл үзүүлэх, шагнаж урамшуулах
- 2.1.5 Аймгийн ИТХ-ын дарга хуулиар олгогдсон бүрэн эрхээ хэрэгжүүлэхтэй холбоотой цаг үеийн шинжтэй зарим арга хэмжээг санхүүжүүлэх.
- 2.1.6. Аймгийн ИТХ-ын нөөц хөрөнгийг орон нутгийн төсөвт нийт дүнгээр тусган аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар батлуулна.

### **Гурав. Аймгийн ИТХ-ын нөөц хөрөнгийн зарцуулалт**

- 3.1 Аймгийн ИТХ-ын нөөц хөрөнгийг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлын шийдвэрийг үндэслэн аймгийн ИТХ-ын даргын захирамжаар зарцуулна.
- 3.2 Аймгийн ИТХ-ын нөөц хөрөнгийг зарцуулах шийдвэр нь тухайн жилийн орон нутгийн төсөвт батлагдсан аймгийн ИТХ-ын нөөц хөрөнгийн нийт хэмжээнээс хэтрэхгүй байна.

### **Дөрөв. Аймгийн ИТХ-ын нөөц хөрөнгийг санхүүжүүлэх, гүйцэтгэлийг тайлагнах**

- 4.1 Аймгийн ИТХ-ын нөөц хөрөнгөөс зардал гаргах нөхцөлд хариуцан гүйцэтгэх байгууллага, ажилтан уг арга хэмжээг хэрэгжүүлэх саналын төлөвлөгөө, төсвийн зардлын дэлгэрэнгүй тооцоог аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдэд ирүүлнэ.
- 4.2 Аймгийн ИТХ-ын нарийн бичгийн дарга төсвийн зардлын тооцоог аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээр хянуулан Тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцүүлсний үндсэн дээр аймгийн ИТХ-ын даргын захирамж гаргуулна.
- 4.3 Тухайн арга хэмжээ, төслийг хариуцан гүйцэтгэж байгаа байгууллага, ажилтан хөрөнгийн зарцуулалтын тайланг уг арга хэмжээг хэрэгжүүлж дууссанаас хойш ажлын 15 хоногийн дотор гаргаж, аймгийн ИТХ-ын ажлын албанд ирүүлнэ.
- 4.4 Аймгийн ИТХ-ын нөөц хөрөнгийн зарцуулалт, тайлагналтыг аймгийн ИТХ-ын нягтлан бодогч хариуцан гүйцэтгэнэ.

### **Тав. Бусад зүйл**

- 5.1 Энэ журамд зааснаас бусад зориулалтаар аймгийн ИТХ-ын нөөц хөрөнгөөс хөрөнгө оруулалтын зардал гаргах, олгосон хөрөнгийг зориулалт бусаар зарцуулахыг хориглоно.
- 5.2 Аймгийн ИТХ-ын нарийн бичгийн дарга аймгийн ИТХ-ын нөөц хөрөнгийн зарцуулалт, эх үүсвэрийн үлдэгдлийн талаарх мэдээллийг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралд улирал бүр танилцуулж байна.



**БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2014.09.10

№ 115

Номгон

**Журам батлах тухай**

Монгол Улсын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1 дэх заалтыг үндэслэн аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

Нэг. Ерөнхий боловсролын сургуулийн орчинд сурагчид гэмт хэрэг, зөрчилд холбогдох, түүнд өртөж хохирохоос урьдчилан сэргийлэх, хэв журам сахиулах ажилд сурагчдын эцэг, эхийг татан оролцуулах замаар сургуулийн орчинд эргүүлийн үүрэг гүйцэтгэх «Сургуулийн цагдаа» эргүүлийн ажиллах журмыг хавсралт ёсоор баталсугай.

Хоёр. Ерөнхий боловсролын сургуулийн удирдлага сургууль болон түүний орчинд ажиллах “Сургуулийн цагдаа” эргүүлийн үйл ажиллагааг удирдлага зохион байгуулалтаар ханган хяналт тавьж, тасралтгүй явагдах нөхцлийг хангаж ажиллан, тайланг 2015 оны 06 дугаар сарын 01-ний дотор аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдэд танилцуулахыг аймгийн Засаг дарга /Д.Жаргалсайхан/-д даалгасугай.

ДАРГА

Д.ШИРМЭН



Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн  
2014 оны 09 дүгээр сарын 10-ны 115 дугаар  
тогтоолын хавсралт

## “СУРГУУЛИЙН ЦАГДАА” ЭРГҮҮЛИЙН ЖУРАМ

**Журмын зорилго:** Ерөнхий боловсролын сургуулийн орчинд сурагчид гэмт хэрэг, зөрчилд холбогдох, түүнд өртөж хохирохоос урьдчилан сэргийлэх болон сургуулийн орчинд хэв журам сахиулах ажилд сурагчдын эцэг, эхийг татан оролцуулах замаар эргүүл зохион байгуулахад оршино.

**Эрх зүйн үндэслэл:** Монгол Улсын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн арван хоёрдугаар зүйл «Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд иргэдийг татан оролцуулах», 12.1.1 хэсэгт «Иргэдийг нийтийн эргүүлд гаргах» заалт үндэслэл болно.

**Давуу тал:** Сургуулийн орчинд «Сургуулийн цагдаа» эргүүлийн үүрэг гүйцэтгэж байгаа иргэнд ажил олгогч байгууллага хагас өдрийн цалинтай чөлөө олгоно.

**Хэрэгжих хугацаа:** 2014 оны 09 дүгээр сарын 01-ээс 2015 оны 06 дугаар сарын 01-нийг хүртэл хугацаанд хэрэгжинэ.

**Удирдлага зохион байгуулалт:** Аймгийн Боловсролын газар, Ерөнхий боловсролын сургуулийн удирдлага нь сургууль болон түүний орчинд ажиллах «Сургуулийн цагдаа» эргүүлийн үйл ажиллагааг өдөр тутмын удирдлага зохион байгуулалтаар хангаж хяналт тавин, тасралтгүй явагдах нөхцлийг хангаж ажиллана.

Ерөнхий боловсролын сургуулийн захирал тухайн хичээлийн жилд сургуулийн орчинд эргүүлийн үүрэг гүйцэтгэх сурагчдын эцэг, эх (асран хамгаалагч, харгалзан дэмжигч)-ийн хуваарийг гаргаж, батлан эргүүлд ажиллах иргэдэд урьдчилан 7 хоногийн өмнө мэдэгдэнэ. Эргүүлийн хуваарийг хичээлийн өглөөний ээлж (07.30-13.30 цаг), өдрийн ээлж (13.30-19.30 цаг)-т тус бүр хоёр хүн гарахаар зохион байгуулна.

Цагдаагийн байгууллага, сургуулийн удирдлага эргүүлд ажиллаж байгаа сурагчдын эцэг, эх (асран хамгаалагч, харгалзан дэмжигч)-д мэргэжил, арга зүйн дэмжлэг тусалцаа үзүүлж, гэмт

хэрэг, зөрчлийн талаарх мэдээлэлд шуурхай очиж ажиллана.

**Эргүүлийн үйл ажиллагаа, тавигдах шаардлага:** Сургууль болон түүний орчинд ажиллах **«Сургуулийн цагдаа»** эргүүлд 18 насанд хүрсэн, согтууруулах болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл хэрэглээгүй, сэтгэцийн өвчингүй, эргүүлийн үүрэг гүйцэтгэх эрүүл мэндийн чадвартай сурагчдын эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийг урьдчилан гаргасан хуваарийн дагуу ажиллуулна.

Эргүүлийн үүрэг гүйцэтгэх иргэн энэхүү журамтай урьдчилан танилцаж сургуулийн нийгмийн ажилтан, жижүүр багшаас зааварчилгаа авч **«Сургуулийн цагдаа»** гэсэн хантаазыг өмсөж эргүүлд ажиллана.

**Эргүүлд ажиллаж байгаа иргэн дараахь үүрэг хүлээнэ.**

- а/ Сургуулийн бүсэд сурагчдыг гэмт хэрэг, зөрчилд холбогдох, өртөхөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр хөдөлгөөнт эргүүлийн үүрэг гүйцэтгэнэ.
- б/ Хичээл орох болон тарах цагуудад сурагчдыг сургуулийн орчинд байгаа (сургуулийн бүсэд хамаарах) замын хөдөлгөөнд аюулгүй оролцоход дэмжлэг үзүүлнэ.
- в/ Хичээлийн завсарлагаанаар сургуулийн орчинд болон сургууль дотор эргүүлийн үүрэг гүйцэтгэж Монгол Улсын хууль тогтоомж болон сургуулийн дүрэм журмыг мөрдөх талаар шаардлага тавьж ажиллана.
- г/ Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр сургуулийн зүгээс болон Хууль сахиулах байгууллагаас зохион байгуулж буй ажил, арга хэмжээнд идэвхтэй оролцоно.
- д/ Сургуулийн удирдлага, анги даасан багштай харилцан тохиролцсоны үндсэн дээр сурагчдад хууль тогтоомж, мэргэжлээ сонгох зэрэг чиглэлээр яриа таниулга хийж болно.
- е/ Эргүүлийн үүрэг гүйцэтгэх хугацаанд сургуулийн орчинд гэмт хэрэг, захиргааны зөрчил гарсан тохиолдолд мэдээллийг цагдаагийн байгууллагад нэн даруй мэдэгдэнэ.
- ё/ Эргүүлийн үүрэг гүйцэтгэх хугацаанд **«Сургуулийн цагдаа»** хантаазыг бохирдуулж, гэмтээхгүй өмсөж хэрэглэн эргүүлийн үүрэг гүйцэтгэх хугацаа дуусахад ажилласан талаарх илтгэх хуудсыг бичиж хантаазын хамт сургуулийн нийгмийн ажилтан болон жижүүр багшид өгнө.

ж/ Хичээл орж байх үеэр сурагчид хичээл таслан тоглож болзошгүй Интернет цахим тоглоом болон бусад газруудаар эргүүлийн үүрэг гүйцэтгэж сурагчдын хичээл таслалтанд хяналт тавьж ажиллана.

**Хориглох зүйл:** Эргүүлд ажиллаж байгаа иргэн үүрэг гүйцэтгэх хугацаандаа Монгол Улсын хууль тогтоомжийг мөрдөж иргэд, хүүхдүүдтэй зөв боловсон харьцах ба төрийн байгууллагын ажилтны нэр барьж хууль бус үйл ажиллагаа явуулахыг хориглоно.

**“Сургуулийн цагдаа”** эргүүлд ажиллах иргэн хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр таслахыг хориглох бөгөөд хэрэв хуваарийн дагуу эргүүлд ажиллах боломжгүй болсон тохиолдолд энэ талаар сургуулийн удирдлагад гурав хоногийн өмнө урьдчилан мэдэгдэнэ.

**Хариуцлага:** Эргүүлийн үүрэг гүйцэтгэж байгаа иргэн үүрэг гүйцэтгэх хугацаандаа халдлагад өртсөн тохиолдолд Монгол Улсын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн /22-р зүйлийн/ холбогдох заалтын дагуу төрөөс хохирлыг барагдуулна.

Эргүүлийн үүрэг гүйцэтгэхээс санаатай зайлсхийсэн тохиолдолд Монгол Улсын Захиргааны хариуцлагын тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1 дэх хэсэгт (Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргаас харьяа нутаг дэвсгэртээ бүх нийтээр дагаж мөрдүүлэхээр хууль тогтоомжийн дагуу гаргасан шийдвэрийг зөрчсөн бол) заасны дагуу торгуулийн арга хэмжээ ногдуулна.

.....oOo.....



**БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2014.09.10

№ 117

Номгон

**Журам батлах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх заалт, Хот байгуулалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.7 дахь заалт, Газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

Нэг. «Газар чөлөөлөх түр журам»-ыг хавсралтаар баталсугай.

Хоёр. Газар чөлөөлөх болон газар чөлөөлөлтийн бүсэд хамрагдсан иргэд, байгууллагын өмчлөлийн эд хөрөнгийг үнэлэхдээ батлагдсан журмыг мөрдөж ажиллахыг аймгийн Засаг дарга /Д.Жаргалсайхан/-д даалгасугай.

ДАРГА

Д.ШИРМЭН

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн  
2014 оны 09 дугаар сарын 10-ны өдрийн  
117 дугаар тогтоолын хавсралт

## ГАЗАР ЧӨЛӨӨЛӨХ ТҮР ЖУРАМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1 Энэ журмын зорилго нь Хотын хөгжлийн Ерөнхий болон Хэсэгчилсэн төлөвлөгөөнд нийцүүлэн аймгийн Засаг даргын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөр, “Аймгийн тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөө»-нд тусгагдсны дагуу Баянхонгор сумын нутаг дэвсгэрт газар чөлөөлөхтэй холбогдсон иргэн, аж ахуйн нэгж, төрийн байгууллагын хооронд үүссэн харилцааг зохицуулахад оршино.
- 1.2 Гэр хорооллын дахин төлөвлөлтийн үйл ажиллагаанд Хот байгуулалтын тухай хуулийн 4.1-д заасан хот байгуулалт, төлөвлөлтийн үндсэн зарчмыг баримтлан иргэд, олон нийтийн оролцоог хангаж, нийтийн эрх ашгийг эрхэмлэнэ.
- 1.3 Энэ журамд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурьдсан утгаар ойлгоно.
  - 1.3.1. “Гэр хорооллын дахин төлөвлөлт” гэж Ерөнхий болон Хэсэгчилсэн төлөвлөгөөг хэрэгжүүлэх зорилгоор гэр хорооллын газрыг төлөвлөх, чөлөөлөх, барилгажуулах үйл ажиллагааг;
  - 1.3.2. “Сонгосон талбай” гэж аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар баталж дахин төлөвлөлт хийхээр байршил, хэмжээг тогтоосон газрыг;
- 1.4 Аймгийн Засаг дарга гэр хорооллын дахин төлөвлөлтийн ажил, арга хэмжээг Засгийн газрын болон төрийн холбогдох байгууллагын үйл ажиллагааны хөтөлбөр, үндсэн чиглэл, аймгийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн тухайн жилийн зорилт болон улс, орон нутгийн төсөвт тусган хэрэгжүүлнэ.
- 1.5 Аймгийн Засаг дарга сонгосон талбайд дахин төлөвлөлтийн дэд бүтэц, нийгмийн дэд бүтэц, инженерийн шугам сүлжээ, авто зам, замын байгууламжийг улс, орон нутгийн төсвөөр барих ажлыг зохион байгуулна.
- 1.6 Гэр хорооллын дахин төлөвлөлтийн сонгосон талбайд

газар чөлөөлөх ажлын зардлыг улс, орон нутгийн төсвөөс санхүүжүүлнэ.

### **Хоёр. Ажлын хэсэг**

- 2.1 Аймгийн Засаг дарга газар чөлөөлөх ажлыг удирдан зохион байгуулах үүрэг бүхий Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг томилох бөгөөд ажлын хэсэг нь дор дурьдсан чиг үүргийг хэрэгжүүлнэ.
  - 2.1.1. Газар чөлөөлөх явцад гарах аливаа асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж, зөвлөмж, дүгнэлт гаргаж эрх бүхий албан тушаалтанд хүргүүлэх;
  - 2.1.2. Газар, үл хөдлөх эд хөрөнгийн үнэлгээг комисс томилж хийлгэх;
  - 2.1.3 Газар чөлөөлөх ажлыг хэрэгжүүлэхэд шаардагдах төсөв, хөрөнгийн асуудлыг тооцон шийдвэрлүүлэх;
  - 2.1.4 Газар чөлөөлөхтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулах гэрээний загварыг боловсруулж, ашиглах;
  - 2.1.5 Газар чөлөөлөлтийн явцад хяналт тавих, үр дүнг үнэлэх;
  - 2.1.6 Газар чөлөөлөлтийн явцын талаар олон нийтэд тухай бүр мэдээлэл өгөх, сурталчлан таниулах
  - 2.1.7 Газар чөлөөлөх ажлын өдөр тутмын үйл ажиллагааг эрхлэх чиг үүрэг бүхий салбар комисс, нэгжүүдийг байгуулж, тэдгээрийг арга зүйн удирдлагаар ханган ажиллах нөхцөлийг бүрдүүлэх
- 2.2. Ажлын хэсэг нь дээрх чиг үүргээс гадна дараах эрхтэй.
  - 2.2.1. Төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжээс хүн хүч, машин техникийг зөвхөн газар чөлөөлөлтийн ажилд зориулж тодорхой хугацаагаар дайчлан гаргуулах санал тавих эрхтэй бөгөөд уул саналыг эрх бүхий байгууллага, албан тушаалтан шийдвэрлэнэ.
  - 2.2.2. Газар чөлөөлөлтийн ажилд дүйцүүлэх албаны цэргийг ажиллуулах асуудлыг холбогдох газарт нь тавьж шийдвэрлүүлэх
  - 2.2.3 Газар чөлөөлөлтийн бүсэд хамрагдсан айл өрх, албан газрын 75-аас доошгүй хувь нь зөвшөөрч газраа чөлөөлөхөөр тохирсон тохиолдолд зөвшөөрөөгүй үлдсэн хэсгийг нийтийн эрх ашгийн үүднээс албадан чөлөөлүүлэх

арга хэмжээг авах

**Гурав. Дахин төлөвлөлтийн үйл ажиллагаа**

- 3.1 Дахин төлөвлөлт хийх талбайн байршил, хэмжээг тогтоох талаар аймгийн Засаг даргаас өргөн барьсан асуудлыг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал хэлэлцэн шийдвэрлэнэ.
- 3.2 Гэр хорооллын дахин төлөвлөлтийн төсөл хэрэгжүүлэх талбайг сонгоход дараахь шаардлага тавигдана:
- Дэд бүтэц, газар ашиглалтыг сайжруулснаар нийтийн эрх ашигт нийцсэн, хотын хөгжилд тэргүүлэх ач холбогдол бүхий газар байх
  - Стратегийн ач холбогдол бүхий инженерийн бэлтгэл ажил, инженерийн болон нийгмийн дэд бүтэц, нийтээр ашиглах барилга байгууламж барьж байгуулах газар
  - Инженерийн бэлтгэл ажил, инженерийн болон нийгмийн дэд бүтэц, нийтээр ашиглах барилга байгууламжийг холбогдох норм ба дүрмийн дагуу төлөвлөхөд хүрэлцэхүйц хэмжээтэй газар байх
  - Сонгосон талбайд оршин амьдарч байгаа иргэдийн 75-аас доошгүй хувь нь зөвшөөрсөн тохиолдолд бүхэлд нь буюу хэсэгчлэн төлөвлөлтийг хэрэгжүүлж болно
- 3.3 Дахин төлөвлөлтийг хэрэгжүүлэхэд дараах шаардлагыг хангасан байна.
- хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, газар зохион байгуулалтын төлөвлөгөөтэй уялдах;
  - сонгосон талбай дахь газар, үл хөдлөх эд хөрөнгө өмчлөгч, эзэмшигчдийн 75-аас доошгүй хувийн зөвшөөрсөн байх;
  - дахин төлөвлөлтийг хэрэгжүүлэх хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлэсэн байх;
  - дахин төлөвлөлтийг хэрэгжүүлэх хугацааг тодорхойлсон байх;
  - газар, үл хөдлөх эд хөрөнгийн үнэлгээ, эрх шилжүүлэлт, нэгж талбарын өөрчлөн зохион байгуулалт, нөхөх олговор, төлөвлөлтийн санхүүжилт, төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээний болон газар, үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөгч,

эзэмшигчийг нүүлгэх, түр суурьшуулах асуудлыг бүрэн тусгасан төлөвлөгөө боловсруулсан байх;

### **Дөрөв. Газар чөлөөлөх үйл ажиллагаа**

- 4.1 Ажлын хэсэг нь газар чөлөөлөх ажлыг удирдан зохион байгуулах
- 4.2 Хууль ёсны газар, үл хөдлөх хөрөнгө өмчлөгч, эзэмшигч, нарт олгох нөхөх олговрын хэмжээг эрх бүхий байгууллагаар гаргуулан, газар, үл хөдлөх хөрөнгө өмчлөгч, эзэмшигч нартай нэг бүрчлэн гэрээ байгуулж олгох
- 4.3 Нөхөх олговрыг бэлнээр авах, гэр хороололд шинээр барьсан хашаа авах, эдлэн газартай хувийн орон сууц авах, нийтийн орон сууцанд захиалга өгөх зэрэг сонголтуудаас эдлүүлнэ.
- 4.4 Гэрээнд дараах зүйлсийг тусгана.
  - Газар болон үл хөдлөх хөрөнгө өмчлөгч, эзэмшигчийн мэдээлэл:
  - Газар болон үл хөдлөх хөрөнгийн мэдээлэл:
  - Худалдах, худалдан авах тохиролцоо хийсэн тохиолдолд төлбөр төлөх хугацаа:
  - Газар чөлөөлөхтэй холбогдох зардлыг хэрхэн шийдвэрлэх тухай:
  - Орон сууц солих тохиролцоо хийсэн тохиолдолд солих орон сууцны давхар, ерөөний тоо, м<sup>2</sup> –ын хэмжээ, орон сууц ашиглалтанд орох хугацаа:
  - Орон сууцаар солих гэрээ байгуулсантай холбоотой түр суурьшуулах асуудлыг хэрхэн шийдвэрлэх тухай
  - Төсөл хэрэгжих явцад үүсч болох эрсдэл, түүнийг шийдвэрлэх арга зам:

### **Тав. Бусад**

- 5.1. Аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй төрийн болон нутгийн захиргааны бүх шатны байгууллага энэ журмыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.
- 5.2. Газар чөлөөлөлтийн бүсд хамрагдсан айл өрхөд аймгийн хөгжлийн чиг хандлага, түүний ач холбогдлын талаар ухуулан таниулж, богино хугацааны дотор чөлөөлөхөд нь биечлэн нөлөөлсөн бодитой дэмжлэг үзүүлсэн иргэнд урамшуулал олгож болно.



- 5.3 Сонгосон талбайд газар, үл хөдлөх хөрөнгийн эрхийг бусдад шилжүүлэх, худалдах, түрээслэх, барьцаалах зэргийг түдгэлзүүлэх, түр зогсоох арга хэмжээг холбогдох байгууллагууд хэрэгжүүлж ажиллана.
- 5.4. Сонгосон талбай дахь газар, үл хөдлөх эд хөрөнгө өмчлөгч, эзэмшигчдийн 75-аас дээш хувь нь сайн дурын үндсэн дээр эвлэлдэн нэгдэж, оршин суугчдын түр зөвлөлийг байгуулж болно.
- 5.5 Оршин суугчдын түр зөвлөл нь төсөл хэрэгжүүлэгчид дэмжлэг үзүүлэх, газар, үл хөдлөх эд хөрөнгө өмчлөгч, эзэмшигчийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах чиг үүргийг хэрэгжүүлнэ.
- 5.6 Төсөл хэрэгжүүлэгч нь газар, үл хөдлөх эд хөрөнгө өмчлөгч, эзэмшигчтэй гурван талт гэрээг байгуулж, батлагдсан хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний дагуу барилгажуулах ажлыг хэрэгжүүлнэ.
- 5.7 Төсөл хэрэгжүүлэх тусгай зориулалтын компани байгуулсан тохиолдолд аймгийн Засаг даргын захирамжаар төсөл хэрэгжүүлэх эрхийг шилжүүлж болно.
- 5.8. Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, түүний чөлөөт цагт Тэргүүлэгчид шийдвэрлэнэ.

### **Зургаа. Хариуцлага**

- 6.1 Газар чөлөөлөх ажлыг зохион байгуулж хэрэгжүүлэхээр үүрэг хүлээсэн Ажлын хэсэг болон бусад иргэдээс дээрх арга хэмжээнд саад учруулсан, сөрөг ухуулга сурталчилгаа хийн бусдыг уруу татаж ажил цалгардуулсан, хөрөнгийг үндэслэлгүйгээр буруу үнэлсэн, бусадтай хуйвалдан эд хөрөнгийг шамшигдуулан завшсан, бусдад тийм бололцоо олгосон, даалгасан үүргийг хангалтгүй биелүүлж хариуцлага алдсан ажилтан, иргэдэд хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

---- оОо ----



**БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2014.09.10

№ 118

Номгон

**Зарим газар нутгийг орон нутгийн тусгай  
хамгаалалтанд авах тухай**

Монгол Улсын Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.3 дахь заалт, Газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.3 дахь заалтын үндэслэн аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

Нэг. Байгалийн хосгүй өвөрмөц тогтоц, рашааныг хэвээр хадгалан үлдээх зорилгоор Шаргалжуут рашаан орчмын 1577 га газрыг Байгалийн дурсгалт газар, Эрдэнэцогт сумын Баянзүрхийн хонхор орчмын 1542 га газрыг Түүх, соёлын дурсгалт газрын зориулалтаар тус тус орон нутгийн тусгай хамгаалалтад авсугай.

Хоёр. Аймгийн тусгай хамгаалалтад авсан Байгалийн болон түүхийн дурсгалт газрын хил заагийн эргэлтийн цэг зургийг нэгдүгээр хавсралтаар, хамгаалалтын дэглэмийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

Гурав. Байгалийн болон түүх соёлын дурсгалт газрын аймгийн тусгай хамгаалалтад авсантай холбогдуулан аймгийн ИТХ-ын 1995 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 7/6 дугаар тогтоолыг хүчингүй болгосугай.

ДАРГА

Д.ШИРМЭН



**БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2014.10.02

№ 121

Номгон

**Төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах  
арга хэмжээнд зарцуулах зардлын  
хувь хэмжээ тогтоох тухай**

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх заалт, Засгийн газрын 2014 оны 43 дугаар тогтоолыг үндэслэн аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээс **ТОГТООХ** нь:

Нэг. Байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах тухайн жилийн төсвийн орлогын хувь хэмжээг хавсралтаар баталсугай.

Хоёр. Байгалийн нөөц ашигласны төлбөрийг татварын жилд төвлөрүүлж ажиллахыг Татварын хэлтсийн дарга /А.Эрдэнэбилэг/, сумдын Засаг дарга, холбогдох төрийн захиргааны байгууллагуудад үүрэг болгосугай.

Гурав. Байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээний тухайн жилийн зардлыг аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусган, хэрэгжүүлж ажиллахыг аймгийн Засаг дарга /Д.Жаргалсайхан/-д даалгасугай.

ДАРГА

Д.ШИРМЭН

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2014 оны  
10 дугаар сарын 02-ны өдрийн 121 дугаар  
тогтоолын хавсралт

**ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ, БАЙГАЛИЙН  
НӨӨЦИЙГ НӨХӨН СЭРГЭЭХ АРГА ХЭМЖЭЭНД ЗАРЦУУЛАХ  
ТӨСВИЙН ОРЛОГЫН ХУВЬ ХЭМЖЭЭ**

№	Байгалийн баялгийн нөөц ашигласны төлбөрийн орлогын төрөл	Байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хувь, хэмжээний доод хязгаар /нийт орлогын дүнгээс хувиар/ /хуулийн хэмжээ/	Тогтоосон хэмжээ
1	Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөрийн орлого	30 хувь	30 хувь
2	Ан амьтны нөөц ашигласны төлбөрийн орлого	50 хувь	50 хувь
3	Усны нөөц ашигласны төлбөрийн орлого	55 хувь	55 хувь
4	Газрын нөөцийн төлбөрийн орлого	30 хувь	30 хувь

----- оОо -----



## БАЯНХОНГОР АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2014.10.02

№ 122

Номгон

### Комисс томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.5 дахь заалтыг үндэслэн аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

Нэг. Аймгийн хэмжээнд уул уурхайн хайгуул, ашиглалт, нөхөн сэргээлтийн үйл ажиллагаа буй аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаанд хяналт, шалгалт хийх комиссыг дараахь бүрэлдэхүүнтэй томилсугай.

#### ***Баян-Овоо, Бөмбөгөр, Бууцагаан сумын чиглэлд:***

Комиссын дарга: Д.Сайнжаргал - /Аймгийн ИТХ-ын төлөөлөгч, Тэргүүлэгч, аймгийн ИТХ-ын дэргэдэх уул уурхай, байгаль орчны бодлогын хорооны дарга/

Гишүүд:

Б.Төмөрбаатар - /Аймгийн ИТХ-ын төлөөлөгч, Тэргүүлэгч/

Т.Бат-Очир - /Аймгийн ИТХ-ын төлөөлөгч, Тэргүүлэгч/

Д.Мөнхсайхан - /Аймгийн ИТХ-ын төлөөлөгч, Тэргүүлэгч/

Б.Оюутболд - /Аймгийн Цагдаагийн газрын дарга/

А.Эрдэнэбилэг - /Аймгийн Татварын хэлтсийн дарга/

Х.Бат-Оргил - /Аймгийн Байгаль орчны газрын дарга/

Г.Хүрэлсүх - /Аймгийн Засаг даргын Тамгын газрын хөгжлийн

бодлогын хэлтсийн байгаль орчин, уул уурхай, газрын харилцааны асуудал мэргэжилтэн/

Ц.Болорчимэг - /Аймгийн Мэргэжлийн хяналтын газрын Байгаль орчны улсын байцаагч/

Б.Мөнхтогтох - /Бөөнцагаан нуур, Байдраг голын сав газрын захиргааны гадаргын усны нөөц хариуцсан мэргэжилтэн/

**Галуут, Жаргалант, Заг, Гурванбулаг сумын чиглэлд:**

Комиссын дарга: Ж.Дашцэрэн - /Аймгийн ИТХ-ын төлөөлөгч, Тэргүүлэгч, дэд бүтэц хөрөнгө оруулалтын бодлогын хорооны дарга/

Гишүүд:

Л.Доржхорлоо- /Аймгийн ИТХ-ын төлөөлөгч, Тэргүүлэгч/

Ч.Сайнбилэг - /Аймгийн ИТХ-ын төлөөлөгч, Тэргүүлэгч/

Д.Цэрэнхорлоо-/Аймгийн ИТХ-ын төлөөлөгч, Тэргүүлэгч/

Ц.Очирбал - /Аймгийн ИТХ-ын төлөөлөгч, Тэргүүлэгч/

Б.Гантулга - /Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлогын хэлтсийн дарга/

Э.Энхбат - /Аймгийн Мэргэжлийн хяналтын газрын дарга/

Г.Жавхлан - /Бөөнцагаан нуур, Байдраг голын сав газрын захиргааны дарга/

Ч.Шийрэв-Арилдий - /Аймгийн Татварын хэлтсийн байцаагч/

Д.Доржготов - /Аймгийн Цагдаагийн газрын эдийн засгийн ахлах төлөөлөгч/

Б.Наранбаатар - /Байгаль орчны газрын уул уурхайн асуудал хариуцсан мэргэжилтэн/

Хоёр. Комиссууд 2014 оны 10 дугаар сарын 06-07-ны өдрүүдэд чиглэлийн дагуу ажиллаж, комиссын дүгнэлт, мэдээллийг 2014 оны 10 дугаар сарын 15-ны дотор аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцүүлсүгэй.

ДАРГА

Д.ШИРМЭН



**БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2014.10.20

№ 130

Номгон

**Орон нутгийн өмчит хуулийн этгээд байгуулах тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар 77.2.4 дэх заалтыг үндэслэн аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

Нэг. Баянхонгор сумын Дуурсах 3 дугаар багийн нутаг дэвсгэрт 150 хүүхдийн орон тоо бүхий 12 дугаар цэцэрлэгийг үүсгэн байгуулсугай.

ДАРГА

Д.ШИРМЭН



**БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧИЙН ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2014.12.05

№ 141

Номгон

**Ой тэмдэглэх тухай**

Монгол Улсын “Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай” хуулийн 5 дугаар зүйлийн 5.2 дахь заалт, Засгийн газрын “Ардчилсан хувьсгалын 25 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх тухай” 2014 оны 92 тогтоолыг тус тус үндэслэн аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

Нэг. Аймгийн хэмжээнд 2014 оны 12 дугаар сарын 10-ны өдрөөс эхлэн “Ардчилал, хүний эрхийн өдөр”-ийг ёслол хүндэтгэлтэйгээр нээж 2015 оныг дуустал Ардчилсан хувьсгалын 25 жилийн ойн хүрээнд зохион байгуулах ажлын нарийвчилсан төлөвлөгөөг гаргаж хэрэгжилтийг хангаж ажиллахыг аймгийн Засаг дарга /Д.Жаргалсайхан/-д даалгаж, аймгийн МоАХ-ны дарга /Ц.Сэмжиддорж/-д зөвлөсүгэй.

Хоёр. Ардчилсан хувьсгалын 25 жилийн ойн арга хэмжээг зохион байгуулах үүрэг бүхий аймгийн хорооны бүрэлдэхүүнийг хавсралт ёсоор баталсугай.

ДАРГА

Д. ШИРМЭН



Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2014 оны  
141 дүгээр тогтоолын хавсралт

## **АРДЧИЛСАН ХУВЬСГАЛЫН 25 ЖИЛИЙН ОЙН АРГА ХЭМЖЭЭГ ЗОХИОН БАЙГУУЛАХ ҮҮРЭГ БҮХИЙ АЙМГИЙН ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮН**

Ой зохион байгуулах аймгийн хорооны Дарга:

- Д.Жаргалсайхан /Аймгийн Засаг дарга/

Орлогч дарга:

- Ц.Сэмжиддорж /Аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн дарга/

Нарийн бичгийн дарга - О.Тойвгоо /Аймгийн ЗДТГ-ын дарга/

Гишүүд:

- Б.Төмөрбаатар /Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгч/

- Д.Юндэнбазар /Аймгийн ИТХ-ын нарийн бичгийн дарга/

- Т.Очирбал /АН-ын ХЭГ-ын дарга, өөртэй нь зөвшилцсөнөөр/

- Ц.Идэрмөнх /Аймгийн ХААлбаны дарга/

- А.Рэгзэн /Аймгийн Стандартчилал хэмжил зүйн хэлтсийн дарга/

- Ж.Төмөрбаатар /Баянхонгор сумын Засаг дарга/

- С.Энхболд /Аймгийн ХДТ-ын дарга/

- Б.Ганчимэг /Хүүхдийн Тэмүжин театрын дарга/

- Ш.Чимгээ /МИМСҮТ-ийн захирал, доктор/

- С.Батсүрэн /Соёл, спорт, аялал жуулчлалын газрын дарга/

- Л.Чулуунбат /НЭ-ийн Их эмч/

- Л.Банзрагч-Аймгийн ИТХ-ын төлөөлөгч

- Ц.Ням /МИМСҮТ-ийн багш/

- Х.Сансалмаа /Баянцагаан сумын ИТХ-ын дарга/

- П.Пүрэв /Шуудан холбооны дарга, өөртэй зөвшилцсөнөөр/

- Д.Цэрэнбат /Ардчилсан холбооны удирдлагын зөвлөлийн гишүүн/

- Х.Ёндонжамц /Баянхонгор сумын МоАХ-ны дарга, өөртэй нь

зөвшилцсөнөөр/

- Л.Цэдэнжав /Баянхонгор сумын МЭҮТ-ийн дарга/

- С.Цэдэндамбаа /өндөр настан/



**БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2014.12.15

№ 153

Номгон

**Мэргэжлийн боловсролыг дэмжих тухай**

Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хууль, Засгийн газрын "Ажилтай орлоготой Монгол хүн" хөтөлбөрийн хэрэгжилтийг идэвхижүүлэх, Мэргэжлийн боловсрол, сургалтын тогтолцоог аймгийн хэмжээнд төлөвшүүлэн хөгжүүлэх зорилгоор аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Мэргэжлийн боловсрол, сургалтын тогтолцоог аймгийн хэмжээнд төлөвшүүлэх, дэмжин хөгжүүлэх зорилгоор "Мэргэжлийн боловсрол сургалтын асуудал хариуцсан түр хороо"-г аймгийн ИТХ-ын дэргэд байгуулж, бүрэлдэхүүнийг нэгдүгээр хавсралтаар, хариуцан зохион байгуулах ажлын удирдамжийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Аймгийн Засаг дарга /Д.Жаргалсайхан/-д даалгах нь:
  - 2.1. Аймгийн ИТХ-ын дэргэдэх "Мэргэжлийн боловсрол сургалтын асуудал хариуцсан түр хороо"-ны үйл ажиллагаанд шаардагдах хөрөнгийг санхүүжүүлэх арга хэмжээ авсугай.
  - 2.2. "Мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал хариуцсан түр хороо"-ны судалгааны үр дүн, зөвлөмжийн хэрэгжилтийг аймгийн хөгжлийн төлөвлөлттэй уялдуулан ажиллаж, хорооны үйл ажиллагааг Засаг даргын дэргэдэх МБС-ын асуудал эрхэлсэн албадын үйл ажиллагаатай уялдуулан ажилласугай.
  - 2.3. "Мэргэжлийн боловсрол сургалтын асуудал хариуцсан

түр хороо”-ны шийдвэр, зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлыг орон нутагтаа шуурхай зохион байгуулж, хамтран ажиллахыг сумын ИТХ-ын дарга нарт зөвлөж, аж ахуйн нэгж, байгууллагын удирдлагуудад уриалсугай.

3. Тогтоолын хэрэгжилтийн явцыг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдаанд 2015 оны эхний хагас жилд багтаан хэлэлцүүлэхийг түр хорооны дарга / Д.Юндэнбазар /-д үүрэг болгосугай.

ДАРГА

Д. ШИРМЭН

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2014 оны  
12 дугаар сарын 15-ны 153 дугаар  
тогтоолын нэгдүгээр хавсралт

**АЙМГИЙН ИТХ-ЫН ДЭРГЭДЭХ “МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛ  
СУРГАЛТЫН АСУУДАЛ ХАРИУЦСАН ТҮР ХОРОО”-НЫ  
БҮРЭЛДЭХҮҮН**

Түр хорооны хорооны дарга:

- Д.Юндэнбазар / Аймгийн ИТХ-ын нарийн бичгийн дарга/

Дэд дарга:

- Д.Ганбаяр /АЗДОрлогч, Аймгийн МБСОНСЗ-ын дарга/
- Т.Бат-Очир /АИТХ-ын Тэргүүлэгч, АОЭХ-ны тэргүүн/

Нарийн бичгийн дарга

- Г.Батбаяр /АЗДТГ-ын НХХ-ийн дарга/

Гишүүд:

- Д.Цэрэнхорлоо / Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгч, НБХ-ны дарга/
- Ж.Төмөрбаатар /Аймгийн ИТХ-ын төлөөлөгч, Баянхонгор сумын Засаг дарга/
- Д. Болдбаатар /Аймгийн ЗДТГ-ын СТСХ-ийн дарга/
- С.Баярмагнай /Аймгийн Хөдөлмөрийн хэлтсийн дарга/
- Ш.Чимгээ /МИМСҮТ-ийн захирал, Доктор/
- Д. Байгальмаа /Аймгийн боловсролын хэлтсийн дарга/
- Д.Полоож /Аймгийн Статистикийн хэлтсийн дарга/
- Ё.Пүрэвдамба /Аймгийн УБХ-ийн дарга/
- Ж.Дуламсүрэн /Аймгийн ХГБХХ-ийн дарга/
- Бямбадорж /Өлзийт МСҮТ-ийн захирал/
- Г.Энхтүвшин /Аймгийн ХАҮТ-ын гүйцэтгэх захирал/
- Цолмонбаатар /Аймгийн ТББ-уудын сүлжээний тэргүүн/
- ...../МБСТ-ийн удирдах зөвлөлийн дарга/
- Б.Хишигбаяр /Хэвлэл мэдээллийн албаны ажилтан/

.....оОо.....

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2014 оны  
12 дугаар сарын 15-ны 153 дугаар  
тогтоолын хоёрдугаар хавсралт

## **АЙМГИЙН ИТХ-ЫН ДЭРГЭДЭХ “МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛ СУРГАЛТЫН АСУУДАЛ ХАРИУЦСАН ТҮР ХОРОО”-НЫ ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН УДИРДАМЖ**

1. Аймгийн хэмжээний мэргэжилтэй ажилтан бэлтгэх болон хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, орон нутгийн бодлогын баримт бичгийг аймгийн хөгжлийн стратегийн төлөвлөгөөтэй уялдуулан сонирхогч /Ажил олгогчид, идэвхтэй ажил хайгчид, мэргэжлийн холбоод, судлаачид/ талуудын оролцоотой боловсруулан ИТХ-аар батлуулах арга хэмжээг 2015 оны эхний хагас жилд багтаан зохион байгуулах
2. Аймгийн ИТХ-ын дэргэдэх “Мэргэжлийн боловсрол сургалтын асуудал хариуцсан түр хороо”-ны ажиллах журам, эрх хэмжээ, үйл ажиллагааныхаа чиглэлийг ИТХ-ын даргаар батлуулан мөрдөж, үйл ажиллагаа явуулах санхүүгийн эх үүсвэрийг аймгийн төсөвт тусган шийдвэрлүүлэх
3. Аймгийн хэмжээнд МБС-ын тогтолцоог дэмжин төлөвшүүлэх үйл ажиллагааны хүрээнд оролцогч төрийн албан хаагчид, сум, багийн засаг дарга нарын болон бусад бүх талууд-(мэргэжлийн холбоод, эзэд, иргэд)-ын гүйцэтгэх үүрэг хариуцлагын хуваарийг нарийн зааглан гаргаж, асуудлыг хариуцан хэрэгжүүлэх байгууллагыг нэр заан өгч мөрдүүлэх асуудлаар Аймгийн ИТХ, Засаг даргаас гаргах шаардлагатай шийдвэрийн төсөл бэлтгэж хэлэлцүүлэх, дээрх асуудал хариуцсан байгууллагуудыг чадавхижуулах арга хэмжээ авч хэрэгжүүлэх ажилд дэмжлэг үзүүлэх
4. МБСҮЗ-ийн орон нутгийн болон үйлдвэрлэлийн салбар зөвлөлүүдийн үйл ажиллагааг аймгийн хэмжээнд уялдуулан зохион байгуулах асуудлаарх журмыг оролцогч талуудын өргөн оролцоотой боловсруулан баталж мөрдүүлэх,
5. Аймгийн хэмжээнд мэргэжилтэй ажилтны эрэлтийг мэргэжлийн холбоод, ажил олгогч эзэд, бизнес эрхлэгчдийн оролцоотой аймаг, сум, багаар тооцон гаргах, эрэлт хэрэгцээ, шаардлагад нийцсэн чадамжид суурилсан мэдлэг, ур чадвар бүхий мэргэжилтэй ажилтан бэлтгэх ажлыг МБС-ын байгууллагаар

- гүйцэтгүүлэх ойрын болон дунд хугацааны төлөвлөгөө гаргаж батлуулах
6. Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих санд хандивлах хувийн хэвшлийн хандивыг бүрдүүлэх, тэдний идэвх оролцоог нэмэгдүүлэх талаар аймгийн хэмжээнд идэвхитэй үйл ажиллагаа зохион байгуулах
  7. Аймгийн хэмжээний МБС-ын талаарх мэдээлэл, сурталчилгааны нийтийг хамарсан ажил (бүх төрлийн мэдээллийн хэрэгслээр)-ыг өргөн хүрээнд зохион байгуулах санал санаачлагыг дэмжих, уг үйл ажиллагаагаар дамжуулан залуучууд, эцэг эх, аж ахуй эрхлэгчид, төр ба хувийн хэвшил, нийгэм хамт олны дунд Мэргэжлийн боловсрол сургалтын талаар бодит, эерэг имидж бүрдүүлэх, залуучуудын дунд МБС-нд суралцан ур чадвар эзэмшиж орлоготой болох, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, суралцагчид, гэр бүл, ажил олгогчдын дунд МБС-ын тухай ойлголтыг дээшлүүлэхэд анхаарах
  8. Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын материаллаг баазыг бэхжүүлэх, дадлага, сургалтын орчин, нөхцлийг сайжруулахад хувийн хэвшлийн оролцоог дэмжин хамтран ажиллах эрх зүйн орчин бүрдүүлэх судалгаа хийх
  9. МСҮТ төгсөгчдийн ажил эрхлэлтийн судалгааг хийж төгсөгчдийн ажлын байраар хангагдсан байдалд үнэлэлт өгөх
  10. Төгсөгчдийн мэргэжлийн ур чадварыг үнэлэх, шалгах, баталгаажуулах улсын шалгалт авах үйл ажиллагаанд хяналт тавьж хамтран зохион байгуулах, чадамжийн гэрчилгээ гардуулах, ажлын байраар хангах чиглэлийн удирдамж гаргаж байх
  11. МБС-ын талаарх хувийн хэвшлийнхний байр суурийг байнга сонсож, гарсан санал хүсэлтийг шуурхай тусган шийдвэрлэж байх

.....оОо.....



**БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2014.12.15

№ 154

Номгон

**Орон нутгийн өмчийн талаар авах арга хэмжээний тухай**

Монгол Улсын “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай” хуулийн 77 дугаар зүйлийн 77.3 дахь заалт, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2010 оны 52 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчит төсвийн байгууллага болон төсөвт үйлдвэрийн газар эд хөрөнгө олж авах, худалдах, шилжүүлэх, актлах журам”-ын холбогдох заалтууд, байгууллагуудын саналыг үндэслэн аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

Нэг. Улсын төсвийн хөрөнгөөр оруулалтаар Бууцагаан, Баянлиг сумуудад “Шинэ сум” төсөл хэрэгжиж шинээр баригдсан барилгуудыг Улсын комисс хүлээн авсантай холбогдуулан дээрх сумдын төсөвт байгууллагуудад ашиглагдаж байсан хуучин барилгын ашиглалтын чанар байдалд үнэлгээ өгөх, дүгнэлт гаргах комиссыг дараахь бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

***Бууцагаан сумын чиглэлд:***

Комиссын дарга: Д.Жаргалсайхан - /Аймгийн Засаг дарга/

Нарийн бичгийн дарга: Б.Амаржаргал - /Дотоод аудитын албаны дарга/

Гишүүдэд:

Г.Батбаяр - /Аймгийн ЗДТГ-ын НХХэлтсийн дарга/

Х.Далхжав - /Аймгийн Онцгой байдлын хэлтсийн Гамшгаас хамгаалах төлөвлөлт, бэлэн байдал хариуцсан ахлах мэргэжилтэн/

М.Мөнхбат - /Аймгийн МХГ-ын эрчим хүчний хяналтын улсын

байцаагч/

Н.Бүнчинсүрэн - /Аймгийн Боловсролын газрын төсвийн мэргэжилтэн/

Д.Гэрэлчулуун - /Аймгийн Эрүүл мэндийн газрын эдийн засагч/

Д.Ганбаатар - /Аймгийн ИТХ-ын төлөөлөгч, Тэргүүлэгч/

Ч.Сайнбилэг - /Аймгийн ИТХ-ын төлөөлөгч, Тэргүүлэгч/

Ж.Дашцэрэн - /Аймгийн ИТХ-ын төлөөлөгч, Тэргүүлэгч/

Л.Доржхорлоо - /Аймгийн ИТХ-ын төлөөлөгч, Тэргүүлэгч/

Ц.Очирбал - /Аймгийн ИТХ-ын төлөөлөгч, Тэргүүлэгч/

**Баянлиг сумын чиглэлд:**

Комиссын дарга: Д.Ширмэн - /Аймгийн ИТХ-ын дарга /

Нарийн бичгийн дарга: Л.Доржханд - /Аймгийн ИТХ-ын өмчийн мэргэжилтэн/

Гишүүдэд: Б.Гантулга - /Хөгжлийн бодлогын хэлтсийн дарга/

Ч.Сарайдамба - /Аймгийн МХГ-ын дэд бүтэц, Байгаль орчин, Геологи уул уурхайн хяналтын хэлтсийн дарга/

Ж.Батзолбоо - /Аймгийн Онцгой байдлын хэлтсийн Гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагч/

Ж.Энхбаяр - /Аймгийн Боловсролын газрын хөрөнгө оруулалтын мэргэжилтэн/

Д.Алтанцэцэг - /Аймгийн ЭМГ-ын хуулийн зөвлөх/

Д.Мөнхсайхан - /Аймгийн ИТХ-ын төлөөлөгч, Тэргүүлэгч/

Т.Бат-Очир - /Аймгийн ИТХ-ын төлөөлөгч, Тэргүүлэгч/

Б.Төмөрбаатар - /Аймгийн ИТХ-ын төлөөлөгч, Тэргүүлэгч/

Д.Сайнжаргал - /Аймгийн ИТХ-ын төлөөлөгч, Тэргүүлэгч/

Д.Цэрэнхорлоо - /Аймгийн ИТХ-ын төлөөлөгч, Тэргүүлэгч/

Хоёр. Төсөвт байгууллагуудад ашиглагдаж байгаа барилга тус бүрт үнэлгээ дүгнэлт өгч цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний талаарх саналыг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдаанд 2014 онд багтааж хэлэлцүүлэхийг комиссын дарга /Д.Ширмэн/, /Д.Жаргалсайхан/ нарт үүрэг болгосугай.

ДАРГА

Д. ШИРМЭН





**БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2014.12.18

№ 161

Номгон

**Улсын сайн малчинд уламжлах тухай**

Монгол Улсын Засгийн газрын 2009 оны 70 дугаар тогтоолоор батлагдсан “Улсын сайн малчин шалгаруулах журам”-ын 9.4 дэх заалтыг үндэслэн аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Мал аж ахуйн үйлдвэрлэлд олон жил үр бүтээлтэй ажиллаж Монгол Улсын сайн малчны болзол хангасан Монгол Улсын Засгийн газрын 2009 оны 70 дугаар тогтоолын “Улсын сайн малчин шалгаруулах журам”-ын шаардлага, шалгуур үзүүлэлтийг ханган ажиллаж байгаа Баян-Овоо сумын малчин Б.Ёндон, Баянлиг сумын малчин Д.Гантулга, Баянговь сумын малчин Г.Гэрэлдаш, Жаргалант сумын малчин Ж.Рагчаасүрэн, Баян-Өндөр сумын малчин Б.Саандар нарыг “Улсын сайн малчин” цолоор шагнуулахаар тодорхойлолт, материалыг Хүнс, хөдөө аж ахуйн яаманд уламжилсугай.
2. Нэр бүхий хүмүүсийн материалыг холбогдох байгууллагад хүргүүлж шийдвэрлүүлэхийг аймгийн Засаг дарга /Д. Жаргалсайхан/- д даалгасугай.

ДАРГА

Д. ШИРМЭН



**БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2014.12.19

№ 12/1

Номгон

**Тайлангийн тухай**

Аймгийн ИТХ түүний Тэргүүлэгчдээс 2014 онд хийсэн ажлын тайлангийн тухай илтгэлийг хэлэлцээд ТЭМДЭГЛЭХ нь:

Тайлант хугацаанд аймгийн ИТХ-ын хуралдааныг 4 удаа хийж нийт 9 асуудал хэлэлцэн 9 тогтоол, Тэргүүлэгчдийн хуралдааныг 29 удаа хийж нийт 178 асуудлыг хэлэлцэж 161 тогтоолыг батлан гаргасан байна. Үүнээс зарим нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон шийдвэрийг дурдвал Тээврийн хэрэгсэл түр саатуулах байрны төлбөр тогтоох тухай, Аймгийн Нэгдсэн эмнэлэгт ашиглагдаж буй 4D эхо оношилгооны кабинетын ажиллах журам батлах тухай, Элсэлтийн ерөнхий шалгалтанд сурагчдыг амжилттай бэлтгэж оролцуулсан багшийг шалгаруулах болзол журам батлах тухай, Аймгийн Засаг даргын дэргэдэх Цагдаагийн газрын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, хяналт тавих үүрэг бүхий иргэний төлөөллөөс бүрдсэн орон тооны бус “Иргэний зөвлөл”-ийг томилох тухай, Баянхонгор аймгийн Аялал жуулчлалын мастер төлөвлөгөөг батлах тухай, “Малчдын бүлэг” ажиллах журам батлах тухай, Баянхонгор аймгийн Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын хэмжээг шинэчлэн тогтоох тухай, Аймаг, сумын Засаг дарга, Усны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл олгоход хураах тэмдэгтийн хураамжийн хэмжээг тогтоох тухай, Ерөнхий боловсролын сургуулийн орчинд сурагчид гэмт хэрэг, зөрчилд холбогдох, түүнд өртөж хохирохоос урьдчилан сэргийлэх, хэв

журам сахиулах ажилд сурагчдын эцэг эхчүүдийг татан оролцуулах үүрэг гүйцэтгэх “Сургуулийн цагдаа” эргүүлийн журам батлах тухай, Төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах арга хэмжээнд зарцуулах зардлын хувь хэмжээг тогтоох тухай, Мэргэжлийн боловсролыг дэмжих тухай зэрэг олон чухал шийдвэрүүдийг батлан гаргасан байна.

2014 онд аймгийн ИТХ, Тэргүүлэгчид, төлөөлөгчдийн зүгээс аймгийн их түүхэн ой, бүтээн байгуулалтанд анхаарлаа хандуулсан их ажлын жил байсан бөгөөд Тухайлбал: Нийт төлөөлөгчдийн санаачилгаар Ламын гэгээний хийдтэй хамтран үндэсний соёл, шашинаа дээдлэх үйлст хүчин зүтгэж, Ламын гэгээний наймдугаар дүр Данзанжамбалчойжишэнин гэгээнтний аймгийнхаа нийт нутгаар морилж, сүсэгтэн олонтойгоо хийх уулзалтуудыг зохион байгуулах, их ойн бат оршил өргөх зан үйлийн орчныг дэг жаягын дагуу тохижуулах, Баянзүрхийн хийдийг засварлуулах, гэгээнтний төрсөн гэр, хашааг шинэчилж өгөх ажлуудад санаачилга гарган ажилласан бөгөөд ялангуяа аймгийн ИТХ-ын Тэргүүлэгч Д.Сайнжаргал, Ч.Сайнбилэг, Б.Төмөрбаатар, Л.Доржхорлоо, Д.Мөнхсайхан, Д.Ганбаатар, Т.Бат-Очир, Ц.Очирбал, төлөөлөгч Г.Батжаргал, М.Батбаяр нарын олон хүмүүс манлайлан ажилласныг тэмдэглэх нь зүйтэй. Мөн төлөөлөгчид тойрогтоо хүрч ажиллан олон бүтээлч ажлыг хийхийн зэрэгцээ Баянхонгор сумаас сонгогдсон төлөөлөгч Ч.Сайнбилэг, Д.Ганбаатар, Д.Мөнхсайхан, Б.Төмөрбаатар, Ж.Дашцэрэн, Л.Доржхорлоо, Д.Цэрэнхорлоо, Ж.Дулмаа, А.Тарав нар нь нэн ядуу амьдралтай өрхүүдийг утаа бага ялгаруулдаг зуухаар хангах зэрэг бүтээлч санаачилгуудыг гаргаж ажиллалаа.

“Нутгийн өөрөө удирдах байгууллагын чадавхийг бэхжүүлэх нь” төслийн хүрээнд Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлуудын цахим хуудас Khural.mn сайт бий болж улсын хэмжээнд бүх шатны хурлуудын талаар мэдээ мэдээлэл солилцох, сайн туршлага судлах нэгдсэн систем бий болсон бөгөөд аймаг, сум, дүүргийн ИТХ-ын дэд цахим хуудсыг хөгжүүлэх, тэдгээрийн мэдээ мэдээллийн чанар, стандартыг сайжруулах зорилгоор “Khural.mn” Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлуудын нэгдсэн портал, интерактив цахим хуудасны дэд цахим хуудсыг хөгжүүлэх” уралдааныг аймаг, сум, дүүргийн бүх шатны Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дунд зарласан бөгөөд улсын хэмжээнд шалгарах 5 аймгийн ИТХ-ын нэгээр манай аймгийн ИТХ шалгарлаа.

Улсын Их Хурлын Тамгын газар, Швейцарийн хөгжлийн агентлаг, НҮБ-ын хөгжлийн хөтөлбөрөөс хамтран хэрэгжүүлж буй “Орон нутгийн шийдвэр гаргах түвшинд иргэдийн оролцоог дэмжих” улсын хэмжээнд зарлагдсан 16 тэтгэлгийн нэгээр шалгарч, тэтгэлгийг амжилттай хэрэгжүүлж хэрэгжилт, үр дүн, сайн туршлагыг улсын хэмжээнд танилцуулсан зэрэг онцлог ажлуудыг дурдаж байна.

Мөн аймгийн ИТХ, түүний Тэргүүлэгчдээс бодлого тодорхойлох, тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх талаар олон чухал арга хэмжээг авч хэрэгжүүлсэн боловч хурлын байгууллагаас гарсан тогтоол шийдвэрийг хэрэгжүүлэх ажил хангалтгүй байсаар байгаа нь хурлын байгууллага, эрх бүхий албан тушаалтнаас гаргасан шийдвэрийнхээ хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллах асуудалд онцгой анхаарч ажиллах шаардлагатай байгааг харуулж байна.

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5 дахь заалтыг үндэслэн аймгийн ИТХ-ын ээлжит бус XII хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Аймгийн ИТХ, түүний Тэргүүлэгчдээс 2014 онд зохион байгуулсан ажил, үйл ажиллагааг “Хангалттай” гэж дүгнэсүгэй.
2. Аймгийн ИТХ-ын дэргэдэх бодлогын хороодыг ажиллах нөхцөл боломжоор хангах, хороодын үйл ажиллагааг аймгийн Засаг даргын Тамгын газрын бодлогын хэлтсүүдийн үйл ажиллагаатай уялдуулах, мэдээ мэдээллээр хангаж ажиллахыг аймгийн ИТХ-ын нарийн бичгийн дарга /Д.Юндэнбазар/, аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /О.Тойвгоо/-д даалгасугай.

ДАРГА Д.ШИРМЭН



**БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2014.12.19

№ 12/2

Номгон

**Төсөвт тодотгол хийх тухай**

Төсвийн тухай хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1.2, 34 дүгээр зүйлийн 34.2.1 дахь заалт, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2 дахь заалт, Улсын Их хурлын 2014 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн Төсөвт тодотгол хийх тухай тогтоолыг тус тус үндэслэн аймгийн ИТХ-ын ээлжит бус XII хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Аймгийн Засаг даргын Тамгын газрын Архивын тасгийн өөрийн орлогыг 5 740.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж төсвийн нийт орлогыг 5 684 291.0 мянган төгрөгөөр, Улсын төсвийн санхүүгийн дэмжлэгийг 19 341.7 мянган төгрөгөөр бууруулж 12 204 985.9 мянган төгрөгөөр, Тусгай зориулалтын шилжүүлгийг 205 887.0 мянган төгрөгөөр бууруулж 34 399 020.4 мянган төгрөгөөр, Орон нутгийн хөгжлийн сангийн орлогыг 1 012 174.3 мянган төгрөгөөр бууруулж 14 448 465.1 мянган төгрөгөөр баталсугай.
2. Аймгийн давсан орлого 5740.0 мянган төгрөгийг Архивын тасгийн цалин, бичиг хэргийн зардалд баталсугай.
3. Төсөвт байгууллагуудын урсгал зардлыг дараахь байдлаар бууруулан баталсугай.

/мян.төг/

№	Байгуулага	2014 год-1	2014 год-2	Зөрүү
1	Аймгийн ИТХ	337 651.6	324 468.5	-13 183.1

2	Аймгийн ЗДТГ	1 117 764.8	1 115 764.8	-2 000.0
3	Байгаль орчны газар	354 769.2	332 068.3	-22 700.9
4	Татварын буцаан олголт	585 315.9	541 330.0	-43 985.9
5	Ангилагдаагүй зардал	912 974.8	907 661.6	-5 313.2
	<b>Нийт дүн</b>	<b>3 308 476.3</b>	<b>3 221 293.2</b>	<b>-87 183.1</b>

4. Төсвийн байгууллагуудын урсгал зардлын хэмнэлт 87 183.1 мянган төгрөгийг дараахь байдлаар хуваарилан баталсугай

/мян.төг/

№	Байгууллага	Дүн
1	90 жилийн ой тэмдэглэсэн нэр бүхий 8 сумын бүтээн байгуулалтад	40 000.0
2	Дотоод аудитын албаны цалин, үйл ажиллагааны зардал	5 000.0
3	Засаг даргын нөөц хөрөнгө	30 000.0
4	ИТХ-ийн үйл ажиллагааны зардал	12 183.1
	<b>Нийт дүн</b>	<b>87 183.1</b>

5. Сумдад олгох санхүүгийн дэмжлэгийг дараахь байдлаар тодотгон баталсугай.

/мян.төг/

№	Сумдын нэр	2014 тод-1	2014 тод- 2	Зөрүү
1	Баянговь	596889.9	595922.9	-967.0
2	Заг	486218.5	485251.5	-967.0
3	Шинэжинст	526499.7	525532.7	-967.0
4	Жинст	504218.5	503251.5	-967.0
5	Баян-Овоо	421218.9	420251.9	-967.0
6	Жаргалант	541006.3	540039.3	-967.0
7	Баацагаан	607557.7	606590.7	-967.0
8	Хүрээмарал	553096.0	552129.0	-967.0
9	Бууцагаан	576006.0	575039.0	-967.0
10	Өлзийт	545861.4	544894.4	-967.0
11	Баянлиг	613289.1	612322.1	-967.0
12	Гурванбулаг	513432.8	512465.8	-967.0

13	Баянбулаг	481803.9	480836.9	-967.0
14	Бөмбөгөр	576846.3	575879.3	-967.0
15	Баян-Өндөр	578758.9	577791.9	-967.0
16	Эрдэнэцогт	641250.2	640283.2	-967.0
17	Баянцагаан	573465.7	572498.7	-967.0
18	Богд	554619.8	553652.8	-967.0
19	Галуут	702224.5	701257.5	-967.0
20	Баянхонгор	2881084.0	2880115.2	-968.8
		13475348.0	13456006.3	-19341.7

6. Тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын зардлыг нэгдүгээр хасвсралтаар баталсугай.
7. Орон нутгийн хөгжлийн сан, Улсын төсвийн хөрөнгө оруулалтын ажлын хяналтын зардлын үлдэгдэл 70 000.0 мянган төгрөгийг Баянхонгор сумын Ногоон хэрэм төслийн зардалд баталсугай.
8. Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн дутуу санхүүжилт 381 806.3 мянган төгрөг, Орон нутгийн төсвөөс санхүүжих 57640.0 мянган төгрөг нийт 439 446.3 мянган төгрөгийг дараахь хөрөнгө оруулалтын ажлаас хасч тодотгосугай.

/мян.төг/

№	Хөрөнгө оруулалт	Дүн
1	2014 оын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтын ажлуудын хэмнэлт	77 701.0
2	Жижиг дунд үйлдвэрийг байгуулахад дэмжлэг үзүүлэх	53 557.2
3	Сүү, сүүн бүтээгдэхүүн, нарийн ногоо боловсруулах үйлдвэр байгуулах төсөл	100 000
4	Төв талбайд байрлуулах 6*4 хэмжээтэй LED дэлгэц 8*3 хэмжээтэй угсардаг тайз авах	20 000
5	Мөнгөн усны хор илрүүлэгч "LUMIX" тоног төхөөрөмж авах	85 000
6	Хадлан тэжээлийн нөөц бүрдүүлэх	98 188.1
7	Эвдэрч сүйтгэгдэж, унаган төрхөө алдаж буй түүх соёлын дурсгалт зүйлсийн хадгалалт хамгаалалтыг сайжруулах, хайсжуулах, самбар хийх	5 000
	<b>Нийт дүн</b>	<b>439 446.3</b>

Аймгийн орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас сумдад олгох орон нутгийн хөгжлийн сангийн шилжүүлгийг дараахь байдлаар бууруулан баталсугай.

/мян.төг/

№	Сум	2014 бат	2014 год	Зөрүү
1	Галуут	360 886.9	335 822.9	- 25 064.0
2	Баян-Овоо	315 027.8	293 148.8	- 21 879.0
3	Эрдэнэцогт	337 112.4	313 699.6	- 23 412.8
4	Бууцагаан	358 496.7	333 598.7	- 24 898.0
5	Жинст	335 770.4	312 450.8	- 23 319.6
6	Богд	344 818.0	320 870.0	- 23 948.0
7	Баянлиг	487 640.0	453 773.0	- 33 867.0
8	Баянговь	376 667.1	350 507.1	- 26 160.0
9	Гурванбулаг	343 128.1	319 297.5	- 23 830.6
10	Жаргалант	350 066.9	325 754.4	- 24 312.5
11	Заг	303 196.6	282 139.3	- 21 057.3
12	Баацагаан	403 261.6	375 254.6	- 28 007.0
13	Бөмбөгөр	318 950.5	296 799.0	- 22 151.5
14	Өлзийт	308 191.1	286 786.9	- 21 404.2
15	Хүрээмарал	337 708.6	314 254.4	- 23 454.2
16	Баянбулаг	348 849.0	324 621.0	- 24 228.0
17	Шинэжинст	588 833.6	547 938.3	- 40 895.3
18	Баянцагаан	390 788.5	363 647.8	- 27 140.7
19	Баян-Өндөр	576 575.1	536 531.2	- 40 043.9
20	Баянхонгор сум	1 060 521.5	986 867.1	- 73 654.4
21	Баянхонгор аймаг	7 214 149.0	6 774 702.7	- 439 446.3
	<b>Нийт</b>	<b>15 460 639.4</b>	<b>14 448 465.1</b>	<b>-1 012 174.3</b>

10. Аймгийн төвийн байгууллагуудын зардлын эдийн засгийн дэлгэрэнгүй ангилалыг хоёрдугаар хавсралтаар баталсугай.

ДАРГА

Д.ШИРМЭН